



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/47

Номгон

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх
үндэсний хөтөлбөр”-ийг 2023 онд хэрэгжүүлэх
арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн 2023 оны Хөгжлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах хавсралтын 16 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 10.000.000 (Арван сая) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-т зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг тухай бүр зохион байгуулж үр дүнг тооцож ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

842310117

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын
23-ны өдрийн А.А.Т. дугаар захирамжийн хавсралт

**БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго		Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлнэ.				
Үр нөлөө		Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх иргэдийн эрх зүйн ухамсар дээшилнэ.				
№	Хэрэгжүүлэх ажил	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Төсөв
1	2	3	4	5	6	7
Зорилт Нэг. Бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.						
1.1.	Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран зорилтот бүлгийн иргэдэд хуулийн мэдлэг олгох эрх зүйн анхан шатны сургалт зохион байгуулж, зөвлөгөө, мэдээлэл өгөх	Сургалтыг 100 иргэнд зохион зохион байгуулж эрх зүйн зөвлөгөө өгснөөр	Жилийн турш	Хууль зүйн туслалцааны төв	Хууль, эрх зүйн хэлтэс	300.0
1.2.	Хууль, захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шийдвэрийг иргэдэд онцлох байдлаар хүргэх эрх зүйн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Bayankongor.gov.mn цахим веб хуудсанд байршуулах	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	-	500.0
Зорилт Хоёр. Шаардлагатай техник, санхүү, хүний нөөцийг бүрдүүлж, тогтсон мэдээллийн сувгуудыг бий болгон тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.						

1	2	3	4	5	6	7
2.1.	Гэмт хэрэг ихээр гардаг сумдад төлөвлөгөөний дагуу соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулж үр дүнг тооцох	Төлөвлөгөөний биелэлтийн хувиар	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Цагдаагийн газар	700.0
2.2	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар холбогдох алба хаагчдад сургалт зохион байгуулах	Сумдын холбогдох алба хаагчдад төлөвлөгөөт сургалт зохион байгуулах	Хагас жилд	Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль, эрх зүйн хэлтэс	
2.3.	“Эрх зүйн хөтчийн булан”-ийн мэдээг сар бүр шинэчилж иргэдэд мэдээ мэдээлэл олгох.	Иргэдийн эрх зүйн мэдээлэл авах боломж бүрэн бүрдсэнээр	Хагас жилд	Хууль, эрх зүйн хэлтэс	-	-
Зорилт Гурав. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд нийгмийн бүх талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна.						
3.1.	Эрх зүйн хөтөч нарыг Шинээр батлагдсан хууль тогтоомжийн эмхтгэл гарын авлагаар хангах	Гарын авлагаар хангаснаар	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд	3.0 сая/төг
3.2.	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжигч байгууллага, хамт олныг сурталчлах, алдаршуулах зорилгоор “Хуулиа дээдэлье” болзолт уралдааныг зохион байгуулж үр дүнг тооцох	Болзолт уралдааныг зохион байгуулж, үр дүнг тооцсоноор	Жилийн турш	Хууль зүйн туслалцааны төв	Хууль, эрх зүйн хэлтэс	3.0 сая/төг
3.3.	MGL радиотой хамтран эрх зүйн боловсрол олгох соён гэгээрүүлэх мэдээ, мэдээллүүдийг хүргэх	Мэдээ мэдээллийг 2 - оос доошгүй удаа хүргэснээр	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд	500.0
3.4.	Эрх зүйн хөтчийг давтан сургах ажлыг зохион байгуулах.	Сургалтад хамрагдсан эрх зүйн хөтчийн тоо	2-р улиралд	Хууль, эрх зүйн хэлтэс	ХЗДХЯ, ХЗҮХ	2.0 сая/төг
3.5.	Нотариатын үүрэг гүйцэтгэгч нарын судалгааг шинэчлэн боловсруулж, тэдэнд чиглэсэн сургалтын тусгай төлөвлөгөөг аймгийн Нотариатын танхимтай хамтран батлуулж	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90 -ээс дээш хувьтай хангаж ажилласнаар	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Аймгийн нотариатчид	-

1	2	3	4	5	6	7
	хэрэгжилтийг хангаж ажиллах					
3.6.	Сум, байгууллагуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус захиалгат сургалтыг тухай бүр зохион байгуулах.	2000 иргэд, төрийн албан хаагчийг хамруулснаар	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Байгууллагуудын Эрх зүйн хөтөч, сумдын ЗДТГ	-
3.7.	Эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгааны ажилд төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах	Судалгааг хийснээр	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	ТББ-ыг оролцуулах	-
3.8.	Эрх зүйн хөтөч нарт эрх зүйн мэдлэг олгох цахим сургалтыг сар бүр зохион байгуулах	Цахим сургалтыг зохион байгуулсанаар	Улирал тутам	Хууль, эрх зүйн хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар	-
3.9.	Тодорхой түвшний эрх зүйн мэдлэг эзэмшсэн хамт олон болж, үүнийгээ үнэлүүлэн баталгаажуулахад чиглэсэн санал, санаачилга өрнүүлэх арга хэмжээг Сумдын эрх зүйн хөтөч нарт зохион байгуулах	Цахим сургалтыг зохион байгуулсанаар	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар	-